



НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/203 дугаар захирамж, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/203 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд тусгагдан төсөвт өртөг нь нэмэгдэж батлагдсан төсөл, арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, шийдвэрийг мөрдөн ажиллаж, үр дүнг тайлагнахыг Үнэлгээний хорооны дарга (Б.Намсрайжав)-д даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Т.Оргил-Эрдэнэ)-т даалгасугай.

4.Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Г.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Б.МӨНХБАТ

44
Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2023 оны 03 дугаар сарын 22-ны
өдрийн 21/18 дугаар тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

Б.НАМСРАЙЖАВ

(НХОГ-ын Барилга
захиалагчийн хэлтсийн
Ахлах инженер)

ГИШҮҮД:

Г.ТЭМҮҮЖИН

(НЗДТГ-ын Хөгжлийн бодлого,
төлөвлөлтийн хэлтсийн Эрчим
хүчний бодлого төлөвлөлт
хариуцсан мэргэжилтэн)

О.БАТБААТАР

(НХОГ-ын Хууль, дотоод хяналтын
хэлтсийн Дотоод хяналтын
мэргэжилтэн)

Ч.НЯМДАВАА

(Хан-Уул дүүргийн 2 дугаар
хорооны иргэн)

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

Г.БАТ-ЭРДЭНЭ

(НХОГ-ын Барилга
захиалагчийн хэлтсийн
Ус хангамж, ариутгах
татуургын хяналтын инженер)